

АВТОТЭЭВРИЙН"ТАВ"ХК-ИЙН

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

УБ хот

2025.04.30

"ТАВ"ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал Улаанбаатар хот Сонгино хайрхан дүүрэг 38-р хороо "ТАВ"ХК-ийн хурлын танхимд 09:00-д эхлэв.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн 2025 оны 03-р сарын 21 өдрийн 25/01 тоот тогтоолын агуулгыг уншиж танилцуулж,хурлын ирцийн талаарх мэдээг Тооллогын комиссын дарга Ж.Нарангэрэл –ийг танилцуулна уу.гэлээ

Хурлын ирцийг Тооллогын комиссын дарга Ж.Нарангэрэл танилцуулснаар :Тооллогын комиссын шийдвэр: "Саналын эрхтэй 114.737 ширхэг хувьцаа эзэмшигчдийн 101.484 ширхэг буюу нийт саналын эрхтэй хувьцааны 88,4 %-ийг төлөөлсөн хувьцаа эзэмшигчид хүрэлцэн ирсэн байна. Иймд Компаний тухай хуулийн 69-р зүйлийн 69.1 дэх заалтыг үндэслэн хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцов.Нийт 114.737 ширхэг хувьцаа эзэмшигчдээс 101.484ш хувьцаа эзэмшигчид / 88,4хувь / ирсэн тул уг хурлыг хүчинтэйд тооцон 09 :15-д хурлыг эхлүүлэв.С.Ганболд ээлжит хурлыг нээж үг хэлж ,хурлын дэгийг танилцуулав.

2024 оны Үйл ажиллагааны тайлан болон төлөвлөгөө

Орон нутгийн тээвэрлэлт бол гэрээний дагуу гүйцэтгэж байна.Уул уурхайн тээвэрлэлт ч гэсэн гэрээний гүйцэтгэж байгаа боловч ханш маш муу хамгийн багаар бодогдож байгаа бас 2022 онд нүүрстээврийн 20 машиныг зээлээр авсан боловч энэ онд шахаж дуусга гэж Хятад талаас шаардлага тавьсаны дагуу бүх анхаарал нүүрстээвэрлэлт рүү шилжиж байна. Нүүрстээвэр өөрөө зардал өндөртэй , ханш унаад ашиг байхгүй тээвэрлэлт болсон, яалтгүй машинуудаа зээлийн гэрээгээр авсан болохоор шахаж дуусгахгүй бол Хятад талаас шахалт орж ирээд байна. .Гэрээний дагуу Эрдэнэс таван толгой ХК болон Энержи ресурс ХХК-ийн экспортолж байгаа нүүрсний тээвэрлэлтэнд явж байгаа боловч давхар бас нийт машинд олгох квотыг хүртэл 60 хувьд нь олгож байна. Автомашины тоо өссөнч нүүрсний ханш бууж аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны доголдол орж тээврийн захиалга 70-80 буурч зогсонги шахуу байдалд хүрсэнийг хэн хүнгүй бүгд мэдэж байгаа. Орон нутгийн тээвэрлэлтэнд бид Монгол улсын 21 аймаг болон сумдад хүнс .мах тоног төхөөрөмж ,тариа буудай,хангамжийн бараануудын хүргэлт, шатахууны тээвэрлэлтийг хийж байгаа ч мөн л тоо багасч дотоодын тээвэрлэлт хүртэл багассан. Улмаар сургалтын байгууллагууд үйлчилгээний газруудын үйл ажиллагаа зогссоноор жолооч нарын мэргэшсэн болон мэргэшүүлэх сургалт тэр дундаа ачаа тээвэр болон зорчигч тээврийн чиглэлээр сургах сургалты

төв 100 хувь зогссон хаасан .Иймд бид 2021 оны 2 дугаар хагасаас эрчимтэй ажиллаж аль болох үйл ажиллагаагаа сайжруулан , ашиг орлогыг 50 хувиар өсгөж ажиллах тал дээр бүх хүчээ дайлчлах хэрэгтэйг бүх шатандаа анхаарч ажиллах болно .

Үйл ажиллагаагаа тэлж тээвэрлэлттэй холбоотой бүх төрлийн тээвэрлэлтийг цаг алдалгүй гүйцэтгэх тал дээр шамдан ажиллах хэрэгтэй гэдгийг надаар хэлүүлэлтгүй мэдэж байгаа байх БНХАУ аас 2021 оны шинэ хово маркийн давхар чиргүүлтэй машинуудаас 3-4 машин худалдан авч нүүрс тээвэрлэлтийн ажилд парк шинэчлэлт хийнэ.Транзит тээвэрлэлт болох Орос Хятад Монгол 3 улсын шуудангийн тээвэрлэлтийг үргэлжлүүлэн гүйцэтгэх ба нэмэлтээр казахстан үзбекстанаас жимс жимгэнэ тээвэрлэх ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна.Өмнөговь аймагт хийгдэж байгаа богины болон уртын тээвэрлэлтийн ажлыг улам эрчимжүүлэх.жолооч нарын ая тухтай орчинг сайжруулах. 3 улсын хооронд хийгдэх транзит ачаа тээвэрлэлтийг байнга тээвэрлэлт хийх.Тээвэрлэлтийн үйл ажиллагааг чанаржуулах ,нэр төрлийг нэмэгдүүлэхэд шамдан ажиллана.

Хэлэлцэх асуудал № 2

2024 оны санхүүгийн тайлан аудитын дүгнэлтийг "ТАВ"ХК-ий Ерөнхий нягтлан бодогч Л.Цогзолмаа босч танилцуулав. Санхүүгийн хямралд өртөхгүйн тулд таналт хийх хэрэгтэйг онцгой анхаарч ажилласан.Нийт хөрөнгийг **5.517.616.590.11** /таван тэрбум таванзуун арван долоон сая зургаан зуун арван зургаан мянга таван зуун ерөн төгрөг арван нэгэн мөнгө / төгрөгөөр Эргэлтийн хөрөнгийг **771.076.921.15** /долоонзуун далан нэгэн сая далан зургаан мянга есөнзуун хорин нэгэн төгрөг арван таван мөнгө /төгрөгөөр,Эргэлтийн бус хөрөнгийг 4.746.539.668.96 /дөрвөн тэрбум долоон зуун дөчин зургаан сая таван зуун гучин есөн мянга зургаан зуун жаран найман төгрөг ерөн зургаан мөнгө / төгрөгөөр 8Өр төлбөрийн нийт дүнг **5.517.616.590.11** /таван тэрбум таван зуун арван долоон сая зургаан зуун арван зургаан мянга таванзуун ерөн төгрөг арван нэгэн мөнгө / төгрөгөөрЭздийн өмчийг **3.030.330.666.61** / гурван тэрбум гучин сая гурван зуун гучин мянга зургаан зуун жаран зургаан төгрөг жаран нэгэн мөнгө / төгрөгөөр Санхүүгийн тайлантай танилцсан байх. Асууж тодруурах зүйл байна уу. Асуутанд хариулаад явъя

Хэлэлцэх асуудал 3

2025 онд Борлуулалт үйлдвэрлэл рүү судалгаа хийж орохгүй бол тээврийн салбар хүнд байдалд орсон мөд гарахгүй .Хятад улс өөрөө үйлдвэрлэлийн орон урд хөршөөс ямар л үйлдвэрлэл оруулж болохоор байна тэрийг судалж монголд нутагшуулах борлуулах, тээвэрлэх, үйлдвэрийг оруулж ирж үйлдвэрлэх чиглэлийг судалж байрьж авья гэсэн төлөвлөгөөтэй ажиллаж байна. Транзит тээвэрлэлтийн ажилд их онцгойрч ажиллана. Үйл ажиллагааны ямар л төрөл дээр тэлж болохоор байна. Дан тээврийн чиглэлээр бол хол явахгүй нь богино настай болсон .Тэр чиглэл рүү эрчтэй хөөцөлдөж санхүүгийн байдлыг сайжруулах тал дээр онцгой анхаарч ажиллана.

Хэдийгээр цар тахал дуусч тээврийн ажлууд орж ирж байгаа ч гэсэн давхар өөр чиглэлээр улам эрчтэй судлаж ажиллах болно.

2025 онд бид

- Европ руу тээвэрлэлт хийх / мах болон техник зөөвөрлөх /
- Орон нутгийн тээвэрт шинээр 2 машин худалдан авч парк шинэчлэлт хийх
- Орос руу жимс жимсгэний тээвэрлэлт хийх
- Нүүрсний тээвэрлэлтийг дан ганц цагаанхад биш өөр боомтуудаар тээвэрлэлт хийх ,урт болон терминал мөн өөр боомтоос ачих ажлыг зохион байгуулах
- 3 улсын хооронд хийгдэх транзит ачаа тээвэрлэлтийг эрчимжүүлэх
- Тээвэрлэлтийн үйл ажиллагааг чанаржуулах ,нэр төрлийг нэмэгдүүлэхэд шамдан ажиллаж байна.
- Европын орнуудыг судалж тээврийн гарц хайж тээвэрлэлтийн замыг нээх,улмаар өргөжүүлж европийн тээвэрлэлтийн хийдэг болох

Хурлын дарга:С.Ганболд босч .Санал асуулгыг нээлээ

С.Ундармаа

Байгууллагын санхүүгийн тайлантай танилцлаа. Зээлийн төлөлтийн талаар мэдээллээ дэлгэрэнгүй өгөх хэр үлдсэн шинээр зээлийн төлөвлөлт байна уу .Тэр зээлийн төлөлт ямар шатандаа явж байна вэ.

Л.Цогзолмаа:

Компаний ерөнхий захирлын нэр дээр авсан зээл .Шинээр машин механизм шинээр авсан байгаа. Энэ тусгагдсан. Байгууллагын зээлийн төлөлт 80%тай явж байгаа.рийн үлдэгдлийн график гаргасан.Тэр графикийн дагуу төлөлт хийгдээд явна. Энэ ондоо шахаж дуусгах төлөвлөгөөтэй байга.

ТУЗ-ийн дарга С.Ганболд :

2024 оны үйл ажиллагааны талаар ерөнхийд нь ярилаа.Санхүүгийн тайлан дээр танилцсан нэмэлт санал бхгүй юу.

С.Ганболд Хэлэлцсэн асуудлаар санал бодол байвал одоо санал аа хэлээрэй.

С.Сэргэлэн :Санал алга.Тайлантай танилцлаа.Үйл ажиллагааны төлөвлөгөөн дээр би хөдөө аж ахуйн тендерүүдийг судал гэж хэлсэн тэрэн дээр түлхүү анхаар мөн барилгын тоног төхөөрөмж барилгын дээврийн төмөр гадна пасадны материалын үйлдвэрийг явж судалмаар байна. Эрээн Замын үүд рүү барилгын ажлын тээвэрлэлтийн ажил үнэ ханш боломжийн гараад байгаан байна .Их боломжийн ажил байна. Мөн өөр чиглэлийн ямар тээвэрлэлт байна. Бас судалж л байхгүй бол тээвэрлэлтээ улам арвижуулах тал онцгой анхаарах хэрэгтэй бүгд мэдэж авсан байх.

С.Ундармаа :Хэлэлцэх асуудлуудтай танилцлаа. Би зөвшөөрч байна. Нүүрсний тээвэрлэлт буурч байгаа энэ хүнд үед нүүрстээвэр биш орон нутгийн тээвэрлэлтийг нэмэх тал дээр л онцгой анхаармаар юм байна. Замын үүд алтанбулгын боомтуудаар орж гарах тээвэрлэлтийг олж авбал ер нь зүгээр юм байна. Энэ жил санхүүгийн хувьд алдагдалд орохгүйн тулд онцгой анхаарч таналт хийх судалгаа явуулж хэрэгжүүлэх хэрэгтэй.Тээвэрлэлт хийлээ гэхэд зардал өндөртэй эрсдэл ихтэйн байна. Түлш нь


үнэтэй явах зам нь урт дээр зардал өндөр гарч байгаан бол өөр салбар луу хүч үзвэл
яасын гэдэг дээр санал нэг байна.

С.Зоригоо: Миний зүгээс санал хүсэлт алга.

С.Сэргэлэн: Бас нэг санал байна. Энэ жил автотээврийн 100 жилийн ой тохиож
байна. 5-р баазын үе үеийн ахмад настангуудыг Автотээврийн 100 жилийн ойн
медалиар шагнамаар байна. Энэ миний л санал шүү.

С.Ганболд : Өөр санал бодол байна уу. Хэрэв байхгүй бол Өнөөдрийг хурлыг үүгээр
өндөрлөё. Хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа. Хурлыг хаасныг мэдэгдэж
хурлын үйл ажиллагаа дууссав.

ТУЗ-ийн дарга:
Гишүүд:



УЛААНБААТАР ХОТ

С.Ганболд

С.Сэргэлэн

С.Ундармаа

С.Зоригоо

Ж.Эрдэнэбилэг

А.Мөнхдулам

Д.Цогзонмаа

Ч.Золзаяа

А.Ишдорж

[Handwritten signatures and notes over the stamp]